

# ЗАЛУУЧУУДЫН ДУУ ХООЛОЙ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

# 2022



**unesco**

Mongolian National  
Commission



ЗАЛУУЧУУДЫН ТӨЛӨӨ  
ЗАЛУУЧУУДАЙ ХАМТ  
ЗАЛУУЧУУД ӨВРСДӨӨ

FOR THE YOUTH  
WITH THE YOUTH  
BY THE YOUTH

Энэхүү судалгааны тайланг ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын хэрэгжүүлж буй “Залуучуудын дуу хоолой” судалгааны төслийн багийн залуу судлаачид боловсруулан гаргав. Тайланд тусгагдсан агуулга нь ЮНЕСКО-ийн болон ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын байр суурийг илэрхийлээгүй болно.

# АГУУЛГА

---

Товчилсон үгийн жагсаалт	4
Талархал	5
Үндэслэл	6
Судалгааны арга зүй	7
Бүлэг 1. Судалгаанд хамрагдсан залуучуудын мэдээлэл	9
Бүлэг 2. Нийгмийн тулгамдсан асуудлууд ба залуучууд	11
2.1. Хүчирхийлэл, зөрчилдөөн	14
2.2. Эрүүл мэнд, өвчин шаналал	16
2.3 Улс төрийн оролцоо ба ардчилсан зарчим	18
2.4 Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал	20
2.5 Зохистой ажлын байр болон боломж	22
Бүлэг 3: Тогтвортой хөгжлийн зорилго-2030 ба залуучууд	24
3.1 ТХЗ-2030 талаарх залуучуудын мэдлэг, ойлголт	26
3.2 Монгол залуучуудын бодлоор хамгийн чухал тогтвортой хөгжлийн зорилгууд	28
Бүлэг 4: Залуучуудад тулгамдаж буй сорилт бэрхшээл	30
4.1 Ажлын байрны хомсдол ба цалингийн хүртээмж	32
4.2 Боловсролын чанар, хүртээмж	33
4.3 Эдийн засгийн асуудал	34
Нэгдсэн дүгнэлт	35
Ашигласан материал	36
Хавсралт	37
Хавсралт-1: Судалгааны асуулт	39

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
МУ	МОНГОЛ УЛС
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА
ТББ	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
ТХЗ	ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО
ТХҮБ	ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
ХБСХ	ХАРААТ БУС СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН
ЮНЕСКО	НҮБ-ЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН, СОЁЛЫН БАЙГУУЛЛАГА

## ТАЛАРХАЛ

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын хэрэгжүүлж буй “Залуучуудын дуу хоолой” судалгааны төслийн залуу судлаачдын баг энэхүү судалгааг ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, Хараат бус судалгааны хүрээлэн ТББ-ын дэмжлэгтэйгээр 2022 оны 08-аас 10 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэв. Энэхүү судалгаагаар 16-24 насны залуучуудын нийгмийн асуудлын талаарх үзэл бодол, Дэлхийд болон Монголд ойрын 10 жилийн хугацаанд сайн сайхан нийгмийг цогцлооход тулгарч буй асуудал, бэрхшээлүүд болон хэрэгцээ, шаардлага, тухайн асуудлыг шийдвэрлэхэд залуучуудын гүйцэтгэх үүрэг, шийдэл, оролцоо, хүлээлтийг тодорхойлохын зэрэгцээ, тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ)-ын талаарх ойлголт, ТХЗ-уудын дэмжлэгтэйгээр залуучуудад тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх боломж, ТХЗ-ууд тусгагдаагүй асуудлыг тодруулахад чиглэсэн. Судалгааны үр дүн нь 16-24 насны залуучуудын өмнө тулгарч буй асуудал, бэрхшээлүүд, тухайн асуудлын өмнө хүлээх үүрэг, шийдэл, оролцооны талаар мэдээлэл авахын зэрэгцээ, тухайн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлоход чухал мэдээллийн эх үүсвэр болно гэж итгэж байна. Тус судалгааг гүйцэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, Хараат бус судалгааны хүрээлэн ТББ-ын хамт олонд болон Бээжингийн багшийн их сургуулийн профессор, Оксфордын их сургуулийн Ногоон Темплтон коллежийн хүндэт гишүүн Роберт Валкерт талархсанаа илэрхийлье. Мөн өөрийн амьдралын туршлага, үзэл бодлоо нээлттэй хуваалцсан нийт судалгаанд оролцогчдод судалгааны багийн зүгээс гүн талархлаа илэрхийлж байна. Тэдгээр хүмүүсийн оролцоо хувь нэмэргүйгээр бид энэ тайланг гаргах боломжгүй юм. Эцэст нь орон нутагт судалгаа зохион байгуулахад хамтран ажилласан орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудын удирдлага, багш, сурган хүмүүжүүлэгч нарт гүн талархал илэрхийлье.

СУДЛААЧИД	
Г. Баясгалан	Залуу судлаач
Г. Даваа	Залуу судлаач
ЗӨВЛӨХҮҮД	
Роберт Валкер	Бээжингийн багшийн их сургуулийн профессор, Оксфордын их сургуулийн Ногоон Темплтон коллежийн хүндэт гишүүн
Н. Янжинпагма	Хараат бус судалгааны хүрээлэн ТББ, Ахлах судлаач, зөвлөх
Х. Баярмаа	Хараат бус судалгааны хүрээлэн ТББ, Ахлах судлаач
Л. Дашзэвэг	Хараат бус судалгааны хүрээлэн ТББ, Ахлах судлаач
ДЭМЖИХ БАГ	
Б. Хулан	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, Нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн
Анна Вейер	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, Културвайт хөтөлбөрийн сайн дурын ажилтан
Н. Нандинцэцэг	Хараат бус судалгааны хүрээлэн ТББ, Төслийн зохицуулагч

## ҮНДЭСЛЭЛ

ЮНЕСКО нь залуучуудын оролцоог хүлээн зөвшөөрч, нийгмийн өөрчлөлтийг бий болгох, ядуурал, тэгш бус байдлыг арилгах, энх тайвныг бэхжүүлэх чиглэлээр залуучуудтай хамтран ажиллахыг эрмэлзэж ирсэн. Хэдийгээр “залуучууд” гэсэн насны бүлгийн талаар олон улсад нэгдсэн байдлаар тогтсон ойлголт байхгүй боловч НҮБ-аас статистикийн зорилгоор 15-24 насныхныг залуучууд гэх ойлголтод хамааруулна гэж тодорхойлсон байдаг.<sup>1</sup> 2021 оны байдлаар МУ-ын нийт хүн ам 3,409,939 ба үүний 1,549,860-ийг буюу 45.5%-ийг 24 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлж байна.<sup>2</sup>

МУ-ын хувьд хүн амын тал орчим хувийг эзэлж буй хүүхэд залуучуудыг дэмжих зорилготойгоор 2017 онд “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”-ийг баталж, уг хуулийн хүрээнд 15-34 насныг залуучууд хэмээн тодорхойлж, төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хуульд (i) хувь хүний хөгжил, (ii) боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан (iii) эрүүл мэнд (iv) хөдөлмөр эрхлэлт (v) аюулгүй амьдрах, хөгжих орчин гэсэн үндсэн таван чиглэлээр зохион байгуулахаар тусгасан байна.<sup>3</sup>

2015 оны 9-р сард НҮБ-ын гишүүн орнууд “Тогтвортой Хөгжил 2030” хөтөлбөрийг баталж, үүний хүрээнд 2030 он гэхэд 17 зорилго, 169 зорилтын хүрээнд дэлхийн улс орнууд өөрт тулгарсан саад бэрхшээлийг даван туулж, ирээдүйд гарч болох эрсдэлээс сэргийлэх талаар хамтран ажиллаж байна.<sup>4</sup> Энэхүү тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд залуучууд идэвхтэй хувь нэмэр оруулж, ТХЗ-г дагаж мөрдөх, хянах үйл явцад оролцооор ирсэн бөгөөд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш ТХЗ-ын хэрэгжилтэд залуучуудын оролцоо чухал хэмээн хэлсэн байдаг.<sup>5</sup>

2020 онд Хараат бус судалгааны хүрээлэнгээс гаргасан “Залуучуудын санал бодлын судалгаа”-ны үр дүнгээс харахад залуучуудын үзэж буйгаар МУ-д хамгийн ихээр тулгамдаж буй асуудлаар ажилгүйдэл, авлига, хээл хахуулийг нэрлэсэн байна.

Түүнчлэн судалгаанд оролцогчдын 46% нь залуучуудыг тийм ч таатай бус ирээдүй хүлээж байна хэмээн хариулсан байна.<sup>6</sup> Мөн сүүлийн жилүүдэд цар тахлын улмаас үүссэн хөл хорио, худал мэдээлэл, эдийн засгийн уналт зэрэг нөхцөл байдлууд нь залуучуудад нийгэмшлийн буюу сэтгэл санааны хямрал, ганцаардлын асуудлууд үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн хэмээн үзэж байна.<sup>7</sup>

2021 оны ерөнхийлөгчийн сонгуулийн ирцийг харахад залуучуудын ирц бусад насныхнаас 8.3%-иар бага буюу хамгийн бага ирцтэй насны бүлэг байна.<sup>8</sup> Улс орныг цаашид авч явах, өөрсдийн шууд болон шууд бус үйлдэл, сонголтоороо нийгэмд томоохон нөлөө үзүүлэх залуучуудын нийгэм, улс төрийн идэвх сул байна.

Энэ бүхнээс харахад залуучуудын нийгэм, улс төрийн идэвх оролцоог сайжруулах, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй бөгөөд үүний тулд юун түрүүнд „Залуучуудад юу хэрэгтэй байна вэ?“, „Залуучууд ямар бэрхшээлтэй тулгардаг вэ?“, „Залуучуудад ямар шийдэл байна вэ?“ зэрэг асуултад үнэн бодитой хариулт олох нь зүйтэй. Тиймээс бид залуучуудын нийгмийн асуудлын талаарх үзэл бодол, тэдэнд тулгарч буй хэрэгцээ шаардлага, сорилт бэрхшээлийг тодорхойлох зорилготойгоор 16-24 насныхныг хамруулсан “Залуучуудын дуу хоолой” судалгааг зохион байгуулсан.

Уг судалгаанд залуучуудын нийгмийн оролцоо, хүний эрх, жендерийн асуудал, сурч боловсрох болон хөдөлмөр эрхлэх боломж, сэтгэл зүйн эрүүл мэнд гэх мэт нийгмийн бүхий л асуудлуудыг хамруулахыг зорьсон болно. Ингэхдээ ЮНЕСКО-ийн “Залуучуудын төлөө, залуучуудтай хамт, залуучуудын өөрсдөө” гэсэн зарчмыг баримтлан залуу судлаачид ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс болон Хараат бус судалгааны хүрээлэн ТББ-ын дэмжлэгтэйгээр судалгааны ажлыг зохион байгуулж, судалгааны тайланг боловсруулав.

<sup>1</sup> Youth | United Nations. (2019). the United Nations.

<sup>2</sup> Монгол улсын хүн амын тоо, 2022, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

<sup>3</sup> Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль. (18, 05 2017). Legalinfo.mn.

<sup>4</sup> Sustainable development goals of Mongolia. (2020). Mongolian SDG dashboard.

<sup>5</sup> World youth report: Youth and the 2030 Agenda for Sustainable Development. (2018). Published

by the United Nations New York, New York 10017 United States of America.

<sup>6</sup> Залуучуудын санал бодлын судалгаа. (2020). Хараат бус судалгааны хүрээлэн.

<sup>7</sup> Я.Мөнхчимэг. (2020). Ковид-19 цар тахал тодорхой бүлгийн залууст хэрхэн нөлөөлсөн бэ?

Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаа II.

<sup>8</sup> Монгол улсын сонгуулийн ерөнхий хороо, 2021.

**Судалгааны зорилго:** Судалгааны зорилго нь 16-24 насны залуучуудын нийгмийн асуудлын талаарх үзэл бодол, дэлхийд болон Монголд ойрын 10 жилийн хугацаанд сайн сайхан нийгмийг цогцлооход тулгарч буй асуудал, бэрхшээлүүд болон хэрэгцээ, шаардлага, тухайн асуудлыг шийдвэрлэхэд залуучуудын гүйцэтгэх үүрэг, шийдэл, оролцоо, хүлээлтийг тодорхойлохын зэрэгцээ, тогтвортой хөгжлийн зорилгын талаарх ойлголт, ТХЗ-уудын дэмжлэгтэйгээр залуучуудад тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх боломж, ТХЗ-уудад тусгагдаагүй асуудлыг тодруулахад чиглэсэн. Энэ хүрээнд тус судалгаагаар дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

## Судалгааны зорилт:

16-24 насны залуучуудын дэлхийд болон Монголд ойрын 10 жилийн хугацаанд сайн сайхан нийгмийг цогцлооход тулгарч буй нийгмийн асуудлын талаарх санаа бодлыг тодорхойлох

Тухайн нийгмийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд залуучуудын гүйцэтгэх үүрэг, шийдэл, оролцоо, хүлээлтийг тодорхойлох


Тогтвортой хөгжлийн зорилгуудын (ТХЗ) талаарх ойлголт болон ТХЗ-уудын дэмжлэгтэйгээр залуучуудад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжийг тодорхойлох



**Судалгааны дизайн:** Тодорхойлон гаргасан зорилтуудыг хангахын тулд тоон арга зүй давамгайлсан, дараалсан холимог дизайныг ашиглав. Судалгааны ажлын хүрээнд тоон мэдээлэл цуглуулан, судалгаанд оролцогчдын хэв шинжийг тодруулан гаргасны дараа тоон дүн шинжилгээний ажлыг гүйцэтгэсэн.

**Судалгааны түүвэр:** “Залуучуудын дуу хоолой судалгаа”-г тоон судалгааны аргаар үндэсний түвшинд судалгааг хийж гүйцэтгэсэн. Уг судалгааны зорилтот бүлэг болох 16-24 насны 600 залуучуудыг санамсаргүй түүврийн аргаар сонгож судалгаанд хамруулсан.

Түүврийн хэмжээг тогтоохдоо эх олонлогоос 95%-ийн итгэх түвшинтэй,  $\pm 5\%$ -ийн алдааны хязгаартайгаар тооцоход түүврийн хэмжээ 600 байна. Энэ нь эх олонлогийг хангалттай төлөөлж чадах түүвэр юм. Талбарын мэдээлэл цуглуулалтыг үндэсний хэмжээнд 2022 оны 08-аас 10 сарын хооронд зохион байгуулсан.




Түүврийн хэмжээ, тоо

**Дүн шинжилгээ, тайлан боловсруулах үе шат:** Судалгааны мэдээллийн хүрээнд талбараас цугласан мэдээллийг бүрэн оруулж дууссаны дараа тайлан боловсруулах шат эхэлсэн. Судалгааны анхдагч мэдээллийг MS EXCEL программд шивж оруулсан бөгөөд энэ явцад гарах алдааг 2%-иас хэтрүүлэхгүйг зорьж ажилласан. Санамсаргүй сонголтын аргаар шивж оруулсан мэдээлэл ба бөглөсөн асуулгыг тулгаж шалгасан. Механик болон логик алдаануудыг шалгаж чанарын шаардлагад нийцүүлсний дараа статистик шинжилгээний SPSS 25.0 программд оруулж, боловсруулалт хийлээ. Судалгааны мэдээллийн боловсруулалтад сонирхож байгаа үзүүлэлтийн дан тоололтоос гадна харьцуулсан шинжилгээний аргыг өргөнөөр ашиглав. Тухайлбал, түүврийн бүлгүүдийн статистик шинжүүд хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай эсэхийг дунджуудыг харьцуулах стьюдентийн t-шинжүүрээр, чанарын хоёр хувьсагчийн хооронд тодорхой мэдэгдэхүйц хамаарал байгаа эсэхийг ки-квадрат шинжүүрээр тус тус шалгасан. Бид эдгээр шинжүүрийг 95%-ийн итгэх түвшинтэй сонгосны үндсэн дээр статистик дүгнэлтүүдээ гаргаж авсан.



# БҮЛЭГ 1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЗАЛУУЧУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд НҮБ-аас залуучууд хэмээн тодорхойлсон 16-24 насны оролцогчдыг сонгож хамруулсан. 2021 оны 3-р сарын байдлаар МУ-ын хүн амын 48% нь Улаанбаатар хотод үлдсэн 52% нь хөдөө, орон нутагт оршин сууж байна. Нийт судалгаанд оролцогчдын 46% нь Улаанбаатар, 54% нь орон нутгаас хамрагдсан байна. Залуучуудын судалгаанд нийт 600 оролцогч хамрагдсанаас 55.8% нь эмэгтэй, 44.2% нь эрэгтэй байна. Судалгаанд оролцогчдыг насны ангиллаар авч үзвэл 16 нас 21.7%, 17 нас 27%, 18 нас 9.7%, 19 нас 7.5%, 20 нас 7.8%, 21 нас 10%, 22 нас 7.5%, 23 нас 5%, 24 нас 3.8% байна.




Ажил эрхлэлтийн хувьд 18.7% нь ажил эрхэлдэг бол, 81.3% нь ажил эрхэлдэггүй буюу оюутан, сурагчид судалгаанд хамрагдсан байна. Боловсролын хувьд:

- 50.2% нь ЕБС-ийн сурагчид бол эдгээрийн 17.8% нь нийслэлийн ЕБС-д суралцагч бол, 32.3% нь орон нутгийн ЕБС-д суралцагч байна.
- 36.2% нь их, дээд сургуулийн оюутнууд ба эдгээрийн дийлэнх буюу 34.5% нь Улаанбаатар хотод дотоодын их, дээд сургуульд суралцагч бол, 0.7% нь орон нутгийн их, дээд сургуульд суралцагч, 0.8% нь гадаадын их, дээд сургуульд суралцагч байна.
- 12.2% нь их, дээд сургуулийн төгсөгчид ба эдгээрийн 10.3% нь ажил эрхэлдэг, 1.2% нь ажил эрхэлдэггүй, 1.5% нь үргэлжлүүлэн магистр/докторын хөтөлбөрт суралцаж байна.
- Харин үлдсэн 1.5% нь их, дээд сургуульд суралцаагүй, ажил эрхэлдэг залуучууд хамрагдсан байна.


Судалгаанд оролцогчдын ихэнх хувийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид эзэлж байгаа бөгөөд А-ийн сурагчдын ихэнх хувийг хөдөө, орон нутгийн сурагчид бүрдүүлж байсан бол их сургуульд суралцагсад болон бакалаврын түвшний боловсролтой иргэдийн ихэнхийг Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчид эзэлж байна.

Судалгаанд оролцсон залуучуудын боловсролын түвшинг, ажил эрхлэлтийн түвшинтэй харьцуулж үзэхэд ЕБС-ийн сурагчдын 1.7% нь хичээлийнхээ хажуугаар цагийн ажил хийдэг гэж хариулсан бол оюутнуудын 18% нь хичээлийнхээ хажуугаар хөдөлмөр эрхэлдэг гэж хариулсан. Харин их, дээд сургууль төгссөн залуучуудын ажил эрхлэлтийн түвшин харьцангуй өндөр буюу 85% гарсан бөгөөд эндээс харахад оюутан, залууст хичээлийнхээ хажуугаар хийж болох цагийн ажлыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Мөн хэдийгээр оюутан, сурагчидтай харьцуулахад их сургууль төгсөгчдийн ажил эрхлэлтийн үзүүлэлт өндөр байгаа боловч хөдөлмөр эрхлэх боломжтой, ажиллахад шаардлагатай боловсрол эзэмшсэн залуучуудын 15% нь ажил эрхлэхгүй байгаагаас төгсөөд удаагүй байгаа ажлын туршлагагүй залуучуудад зориулсан ажлын байр бий болгох, ажлын байрны шаардлагыг (ажлын туршлага шаардах гэх мэт) тохиромжтой байдлаар өөрчлөх хэрэгтэй байгааг харуулж байна.



Ажил эрхлэлт болон боловсролын түвшний харьцуулалт, %

## Залуучуудад нийгмийн амьдралд хэвийн оролцоход саад болж буй бэрхшээлүүд




Судалгааны үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран залуучуудад нийгмийн амьдралд оролцоход бэрхшээл тулгарч байгаа бөгөөд тодруулбал судалгаанд оролцогчдын 17.7% нь нийгмийн амьдралд хэвийн оролцоход ямар нэгэн байдлаар сорилт тулгардаг гэж хариулсан бол 30.8% нь уг асуултад хариулахаас татгалзсан байна. Залуучуудад нийгмийн амьдралд хэвийн оролцоход саад болж буй бэрхшээлүүдийг дурдвал:

- Санхүүгийн боломж, нөхцөл тааруу
- Хүмүүсийн харилцаа, хандлага (Соёлгүй, бүдүүлэг хүмүүс)
- Насаар ялгаварлан гадуурхах (Ажил дээр бага залуу гэж дээрэлхэх, насанд хүрээгүй гэдэг шалтгаанаар үл тоох)
- Хүүхэд харах хүнгүй байх

- Дэд бүтэц, хот төлөвлөлт, замын түгжрэл
- Гудамжинд үг хэлэхдээ хүмүүсээс болгоомжилдог
- Хөдөө, орон нутагт дахь хязгаарлагдмал бололцоо, орчин нөхцөл тааруу
- Аюулгүй орчин нөхцөл байхгүй (золбин нохой) гэх мэт шалтгаануудын улмаас нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож чаддаггүй байна.

Нийгмийн харилцаанд оролцоход бэрхшээл тулгардаг эсэх, %



## БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БА ЗАЛУУЧУУД

Тайлангийн энэ хэсэгт 16-24 насны залуучуудын нийгмийн асуудлын талаарх үзэл бодол, дэлхийд болон Монголд ойрын 10 жилийн хугацаанд сайн сайхан нийгмийг цогцлооход тулгарч буй асуудал, бэрхшээлүүд болон хэрэгцээ, шаардлага, тухайн асуудлыг шийдвэрлэхэд залуучуудын гүйцэтгэх үүрэг, шийдэл, оролцоо, хүлээлтийг авч үзсэн.














Судалгаанд оролцсон залуучуудаас дэлхийд ойрын 10 жилийн хугацаанд сайн сайхан нийгмийг цогцлооход тулгамдаж буй тэргүүлэх ямар асуудал байна вэ гэж асуухад тэдний 55.1% нь хүчирхийлэл, зөрчилдөөн, 47% нь эрүүл мэнд, өвчин шаналал, 44.5% нь уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал, 35.8% нь улс төрийн оролцоо ба ардчилсан зарчим, 34.1% нь худал мэдээлэл ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хэмээн тодорхойлж байна. Харин МУ-ын хувьд хамгийн ихээр тулгамдаж буй асуудлаар 49.5% нь хүчирхийлэл, зөрчилдөөн, 46.1% нь эрүүл мэнд, өвчин шаналал, 44.6% нь улс төрийн оролцоо ба ардчилсан зарчим, 40.3% нь зохистой ажлын байр болон боломж, 35.8% нь худал мэдээлэл ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хэмээн тодорхойлж байна.

**Хүчирхийлэл, зөрчилдөөний асуудалд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү санаа зовж байна.**

Харин дэлхий дахинд сайн сайхан нийгмийг цогцлооход залуучуудын төдийлөн санаа зовохгүй байгаа буюу хамгийн бага сонгогдсон асуудлууд нь соёл, уламжлал алдагдах (11%), шилжилт хөдөлгөөн (14.7%), хиймэл оюун ухаан, шинэ технологи (16.3%), боловсролын чанар, хүртээмж (28.3%), зохистой ажлын байр, боломж (28.5%) хэмээн тодорхойлж байна. Тэгвэл үүнтэй адилаар ойрын 10 жилийн ирээдүйд МУ-д сайн сайхан нийгмийг цогцлооход залуучуудын санааг төдийлөн зовоохгүй байгаа асуудлууд нь хиймэл оюун ухаан, шинэ технологи (4.3%), соёл, уламжлал алдагдах (11.5%), хоол хүнс, ус, амьдрах орон байрны хомсдол (21.3%), шилжилт хөдөлгөөн (24.3%), уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал (26.3%) хэмээн тодорхойлж байна.

Эдгээр асуудлуудыг нас, хүйс, боловсролын түвшин, оршин суугаа газар зэрэг хүн ам зүйн мэдээллээр харьцуулж үзэхэд **хүчирхийлэл, зөрчилдөөний асуудалд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү санаа зовж байна.** Мөн худал мэдээлэл, зохимжтой ажлын байр гэсэн тулгамдсан асуудлуудад хөдөө орон нутагт оршин суудаг хүүхэд, залуучууд нийслэлд амьдарч буй залуучуудаас илүү ихээр санаа зовж байгаа бол улс төрийн оролцоо болон уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд Улаанбаатар хотод амьдарч буй залуучууд илүү ихээр санаа зовж байна. Насны хувьд 18-аас доош насныхан боловсролын чанар, ялгаварлан гадуурхалт, зохимжтой ажлын байр гэсэн асуудлуудад хамгийн ихээр зовниж байгаагаа илэрхийлжээ. Харин 21-ээс дээш насны судалгаанд оролцсон залуучууд 18-аас доош насныхнаас 2 дахин илүү ихээр шилжилт хөдөлгөөнийг асуудал хэмээн харж байна. Мөн түүнчлэн 21-ээс дээш насныхан бусад насныхнаас илүүтэйгээр уур амьсгалын асуудалд анхаарал хандуулж байгаа нь харагдаж байна. Тодруулбал уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг сонгосон хүмүүсийг насаар нь харьцуулж үзэхэд ( $\chi^2(2) = 7,998$ ,  $p = .018$ ,  $\phi = 0.116$ ) буюу 21 болон түүнээс дээш насны залуучууд уур амьсгалын өөрчлөлтийг илүү их асуудал хэмээн тодорхойлж байна. Эдгээр ялгаа нь хүн ам зүйн харилцан хамааралтай шинж чанаруудаас үүдэлтэй байж болох бөгөөд учир нь боловсролын түвшний ялгаа нь насны бүлэг, мөн зарим талаараа газар зүйн байршлын хувьд таарч байгаа юм. Жишээлбэл их, дээд сургуулийн оюутнууд (ихэвчлэн 18-аас дээш насныхан) болон төгсөгчдийн (ихэвчлэн 21-ээс дээш насныхан) 53.6% нь уур амьсгалын өөрчлөлтийг сонгосон бол ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын (ихэвчлэн 18-аас доош насныхан) 34.9% нь л уг асуудлыг сонгосон. Үүнтэй адилаар  $\chi^2(2) = 12.080$ ,  $p = .0102$   $\phi = 0.143$  буюу ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 61.5% нь “хүчирхийлэл, зөрчилдөөн”-ийг хамгийн тулгамдсан асуудлын нэг гэж сонгосон 14 бол их дээд сургуулийн оюутнууд болон төгсөгчдийн 48.6% нь энэ асуудлыг хамгийн чухал асуудлын нэг гэж сонгосон.

## Монголд болон дэлхий дахинд тулгамдаж буй асуудлууд, %

	Тулгарч буй асуудлууд	Дэлхий дахинд	МУ-ын хэмжээнд	Зөрүү	Эрэмбэ	Сонголтын хувь			
						Огт сонгоогүй	Зөвхөн Монголын асуудал	Зөвхөн дэлхийн асуудал	Дэлхийн болон Монголын асуудал
	Хүчирхийлэл, зөрчилдөөн	55.1%	49.5%	-5.6	I	31.7%	13.2%	18.8%	36.3%
	Эрүүл мэнд, өвчин шаналал	47%	46.1%	-0.9	II	37%	16%	16.8%	30.2%
	Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал	44.5%	26.3%	-18.2	VI	49.8%	5.7%	23.8%	20.7%
	Улс төрийн оролцоо ба ардчилсан зарчим	35.8%	44.7%	8.9	III	45.2%	25.7%	16.9%	12.2%
	Худал мэдээлэл ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө	34.1%	35.8%	1.7	IV	48.8%	17.1%	15.3%	18.8%
	Ялгаварлан гадуурхалт ба тэгш бус байдал	32%	29%	-3	VIII	54.8%	13.2%	16.2%	15.8%
	Хоол хүнс, ус, амьдрах орон байрны хомсдол	30.5%	21.3%	-9.2	IX	60%	9.5%	18.7%	11.8%
	Зохистой ажлын байр болон боломж	28.5%	40.3%	11.8	V	49.8%	21.7%	9.8%	18.7%
	Боловсролын чанар, хүртээмж	28.3%	34.5%	6.2	VII	50.8%	20.8%	14.7%	13.7%
	Хиймэл оюун ухаан, шинэ технологи	16.3%	4.3%	-12	XII	92%	3.3%	3.7%	1%
	Шилжилт хөдөлгөөн /хот, хөдөө болон өөр улс/	14.7%	24.3%	-9.6	X	70.3%	15%	5.4%	9.3%
	Соёл уламжлал алдагдах	11%	11.5%	-0.5	XI	81.7%	7.3%	6.8%	4.2%
	Бусад	1%	0.7%	-0.3	XIII	98.3%	0.7%	1%	0%

Судалгааны үр дүнгээс харахад **залуучууд дэлхий дахинд болон МУ-ын хэмжээнд санаа зовж буй асуудлууд нь ижил** байна. Харин залуучуудын хувьд дэлхий болон МУ-ын хэмжээнд тулгамдаж байна гэж үзсэн асуудлууд хоорондоо зөрүүтэй тохиолдол нь дэлхийд **“Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал” байгаа** бол, Монголд “Зохистой ажлын байр болон боломж” хэмээн үзэж байна.

Судалгаанд оролцогчдын 44.5% нь дэлхий дахины хувьд “Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал”-ыг чухал асуудал хэмээн үзсэн боловч, үүнээс 18.2%-иар бага буюу 26.3% нь уг асуудлыг МУ-ын хувьд ойрын 10 жилд санаа тулгамдаж буй бэрхшээл гэж хариулсан байна.

Харин уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг дэлхийд бус зөвхөн Монголын асуудал гэж хариулсан иргэд ердөө 5.7%-ийг эзэлж байна. Эндээс залуучууд уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдлын асуудлыг МУ-д тулгамдаж буй асуудлаас илүүтэйгээр дэлхий дахинд тулгамдаж буй асуудал гэж үзэж байна.

Судалгаанд оролцогчдын **92% нь “Хиймэл оюун ухаан, шинэ технологи”-ийн асуудлыг Монголд, дэлхий дахинд аль алинд санаа зовох асуудал гэж үзэхгүй** байна. Харин 81.7% нь “Соёл, уламжлал алдагдах” гэсэн асуудлыг огт сонгоогүй бөгөөд залуучууд дэлхий дахины төдийгүй МУ-ын хэмжээнд уг асуудалд санаа зовних нь бага байгааг харж болно.

Харин **“Шилжилт хөдөлгөөн /хот, хөдөө болон өөр улс орон/”-ний асуудлыг 70.3% нь тулгамдсан асуудал гэж үзэхгүй** байна. Гэсэн хэдий ч уг асуудлыг МУ-ын хувьд ирэх 10 жилийн хугацаанд санаа зовоох асуудал гэж тодорхойлсон залуучуудын хувь, дэлхий дахины асуудал гэж үзсэн залуучуудын хувиас 9.6%-иар их байна.

Дараагийн хэсгүүдэд дэлхийн болон Монголын түвшинд тэргүүлэх шалтгаан хэмээн сонгосон нийгмийн тулгамдсан асуудлуудыг нарийвчилсан шинжилгээ хийж тайлбарлан харуулна.




# 2.1 ХҮЧИРХИЙЛЭЛ, ЗӨРЧИЛДӨӨН

/Нийт оролцогчдын 68.3% нь сонгосон/



Хүчирхийлэл зөрчилдөөн сонгосон оролцогчдын хэв маяг, % (n=600)



Судалгаанд оролцогчдын 68.3% нь **“Хүчирхийлэл, зөрчилдөөн”-ийг дэлхийд аль эсвэл МУ-ын хэмжээнд хамгийн ихээр санаа зовоож буй 4 гол асуудлын нэг** гэж хариулсан. Тодруулбал залуучуудын 55.1% нь уг асуудлыг дэлхийн дахинд хамгийн ихээр тулгамдаж буй асуудал гэж хариулсан бол, 49.5% нь МУ-д хамгийн ихээр тулгамдаж байгаа асуудлын нэг гэж хариулжээ. Харин нийт судалгаанд оролцогчдын 31.7% нь “Хүчирхийлэл, зөрчилдөөн”-ийг МУ-д ч мөн дэлхий дахинд ч санаа зовох асуудал гэж харахгүй байна. Судалгааны үр дүнгээс харахад уг асуудлыг дэлхийн дахинд тохиож буй бэрхшээл гэж харж буй залуучуудын хувь зөвхөн МУ-д тулгамдаж буй асуудал гэж үзэж буй залуучуудаас 5.6%-иар илүү байна.

Дэлхий дахинд тулгамдаж буй хүчирхийлэл, зөрчилдөөний асуудалд цөмийн зэвсэглэл, дайн, үймээн самуун, жендерт суурилсан хүчирхийлэл зэргийг хамааруулан үзэж байгаа бол дотоодын хэмжээнд хүчирхийлэл, зөрчилдөөнд гэр бүлийн хүчирхийлэл, архи дан согтуурахтай холбоотойгоор бусдыг гэмтээх, цахим орчин дэх гадуурхал зэргийг оруулж үзсэн байна.

МУ-ын хувьд 2022 оны эхний 5 сард 16,850 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 79.8%-ээр өсжээ.<sup>9</sup> 2017 онд Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан “Жендерт суурилсан хүчирхийллийн түүвэр судалгаа” үр дүнгээс харахад МУ-д гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэйн 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртөж байжээ.

“Залуучуудын дуу хоолой” судалгаанд оролцогчдын 55.1% нь дэлхийд ойрын 10 жилийн хугацаанд сайн сайхан нийгмийг цогцлооход тулгамдаж буй асуудлаар “Хүчирхийлэл, зөрчилдөөн”-ийг нэрлэсэн. Хүчирхийлэл зөрчилдөөнийг сонгосон оролцогчдын 59.2% нь эмэгтэйчүүд, үлдсэн 40.8% нь эрэгтэйчүүд байсан. Харин МУ-д ойрын 10 жилд сайн сайхан нийгмийг цогцлооход хамгийн ихээр тулгамдаж буй асуудал нь залуучуудын өнцгөөс дэлхий дахинтай адилаар “Хүчирхийлэл, зөрчилдөөн”

байсан бөгөөд ингэхдээ нийт судалгаанд оролцогчдын 49.5% нь уг асуудалд хамгийн ихээр санаа зовниж байна гэсэн хариултыг өгсөн. “Хүчирхийлэл, зөрчилдөөн”-ийг асуудлаар сонгосон судалгаанд оролцогчдын 58.6% нь эмэгтэйчүүд байсан бол, үлдсэн 41.4% нь эрэгтэйчүүд байсан. “Хүчирхийлэл, зөрчилдөөн”-ийг хамгийн ихээр тулгамдаад буй асуудал гэж үзэж байгаа хүмүүсийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна. Энэ нь “Жендерт суурилсан хүчирхийллийн түүвэр судалгаа”-ны тайланд дурдсантай адилаар эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртөх хувь өндөр байдагтай холбоотой байж болох юм.


**Хөдөө, орон нутагт амьдарч буй залуучуудын хувьд “Хүчирхийлэл, зөрчил мөргөлдөөн” илүү сэтгэл зовоосон асуудал байна.**

Түүнчлэн хөдөө орон нутагт амьдарч буй залуучууд болон хүчирхийлэл, мөргөлдөөнийг дэлхий дахинд ойрын 10 жилд тулгарч буй дөрвөн гол асуудлын нэг гэж хариулсан залуучуудын хооронд бага боловч мэдэгдэхүйц эерэг хамаарал гарсан ( $r = .084, p = .001$ ).


Эндээс харахад Улаанбаатар хотод амьдарч буй залуучуудтай харьцуулахад хөдөө, орон нутагт амьдарч буй залуучуудын хувьд “Хүчирхийлэл, зөрчил мөргөлдөөн” илүү сэтгэл зовоосон асуудал байна.

<sup>9</sup> Үндэсний статистикийн хороо. (2022). Статистикийн мэдээ.

## ДЭЛХИЙД



## МОНГОЛД




# 2.2

## ЭРҮҮЛ МЭНД, ӨВЧИН ШАНАЛАЛ

/Нийт оролцогчдын 63% нь сонгосон/



Эрүүл мэнд, өвчин шаналлыг сонгосон оролцогчдын хэв маяг, % (n=600)



Судалгаанд оролцогчдын 63% нь “Эрүүл мэнд, өвчин шаналал”-ыг дэлхийд аль эсвэл МУ-ын хэмжээнд хамгийн ихээр санаа зовоож буй 4 гол асуудлын нэг гэж үзсэн бөгөөд ингэж үзэж буй залуучуудын 47% нь уг асуудлыг дэлхий дахинд хамгийн ихээр тулгамдаж буй асуудал гэж хариулсан бол 46.1% нь МУ-д хамгийн ихээр тулгамдаж байгаа асуудлын нэг гэж хариулжээ. Харин нийт судалгаанд оролцогчдын 37% нь “Эрүүл мэнд, өвчин шаналал”-ийг МУ-д ч мөн дэлхий дахинд ч санаа зовох асуудал гэж хараагүй байна. Судалгааны үр дүнгээс харахад уг асуудлыг дэлхийн дахинд тохиож буй бэрхшээл гэж харж буй залуучуудын хувь зөвхөн МУ-д тулгамдаж буй асуудал гэж үзэж буй залуучуудаас 0.8%-иар илүү байна.



Дэлхий дахинд тулгамдаж буй “Эрүүл мэнд, өвчин шаналал” асуудалд халдварт өвчин, вакцины хүрэлцээ зэргийг хамааруулан үзэж байгаа бол дотоодын хэмжээнд уг асуудалд эмнэлэг, эмнэлгийн ажилтнуудын хүрэлцээ, хорт хавдрын оношилгоо, эмчилгээ гэх мэт асуудлуудыг оруулж үзсэн байна.

2019 онд анх бүртгэгдсэн КОВИД-19 цар тахлын улмаас дэлхий даяар 615 сая хүн халдвар авч, 6,5 сая хүн амиа алдаж дэлхий нийтийг хөл хорионд ороход хүргэсэн. Түүнчлэн цар тахлын улмаас олон нийтийн дунд үүссэн айдас, сэтгэл зүйн хямрал зэрэг нь өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байна. МУ-д л гэхэд уг вирусээр 983,000 хүн халдварлаж, 2 мянга гаруй хүн амь насаа алдсан билээ.<sup>10</sup>


**Хөдөө орон нутагт харьяалагдаж буй залуучууд Улаанбаатар хотод амьдарч буй залуучуудаас 10.4%-иар илүү уг асуудалд санаа зовж байна.**

Үүнээс гадна МУ-ын хүн амын нас баралтын шалтгааны 85.9 хувийг халдварт бус өвчлөл эзэлж, үүний дотор 3 хүний нэг нь зүрх судасны тогтолцооны өвчин, 4 хүний нэг нь хавдар, 5 хүний нэг нь гэмтэл хордлого, гаднын шалтгааны улмаас нас барж байна.<sup>11</sup> Эрүүл мэнд, өвчин шаналлыг дэлхий дахины асуудлаар нэрлэсэн залуучуудын 41.6% нь эрэгтэй, 58.4% нь эмэгтэйчүүд Монголын нийгэмд тулгамдаж буй бэрхшээл мөн гэж сонгосон иргэдийн 43.6% нь эрэгтэй, 56.3%


эмэгтэй байна. Эндээс харахад **эмэгтэйчүүд эрүүл мэндийн асуудлаар эрэгтэйчүүдээс арай илүү санаа зовниж** байна. Нийт эмэгтэйчүүдийн 48.3% нь уг асуудлыг хамгийн ихээр санаа зовоож буй 3 асуудлын нэгээр сонгосон.

**Эрүүл мэнд, өвчин шаналлыг Монголд тулгамдсан асуудал хэмээн үзэж буй залуучуудыг газар нутгийн байршлаар нь авч үзвэл хөдөө орон нутагт харьяалагдаж буй залуучууд Улаанбаатар хотод амьдарч буй залуучуудаас 10.4%-иар илүү уг асуудалд санаа зовж байгааг харж болно.** Энэ нь хөдөө, орон нутаг дахь эмч, эмнэлгийн ажилтнуудын болон тоног төхөөрөмжийн хүрэлцээ бага байдаг мөн шаардлагатай тохиолдолд аймгийн төв эсвэл Улаанбаатар хот руу явж эрүүл мэндийн үйлчилгээ авдагтай холбоотой байх магадлалтай. Мөн түүнчлэн судалгаанд хамрагдсан залуучуудын 60.5% нь тогтвортой хөгжлийн зорилгуудаас хамгийн чухал зорилгуудын нэгээр “ТХЗ-3: Эрүүл мэндийг дэмжих”-ийг сонгосон бөгөөд энэ нь залуучуудын хувьд эрүүл мэндийн асуудал хамгийн тулгамдаад буй асуудлуудын нэг мөн болохыг нотолж байна.

### ДЭЛХИЙД



### МОНГОЛД



<sup>10</sup> COVID Live - Coronavirus Statistics. (2022). Worldometer.

<sup>11</sup> Эрүүл мэндийн үзүүлэлт, 2019 он


# 2.3

## УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО БА АРДЧИЛСАН ЗАРЧИМ

/Нийт оролцогчдын 54,8% нь сонгосон/



Эрүүл мэнд, өвчин шаналлыг сонгосон оролцогчдын хэв маяг, % (n=600)



Судалгаанд оролцогчдын 54.8% нь “Улс төрийн оролцоо ба ардчилсан зарчим”-ыг дэлхийд аль эсвэл МУ-ын хэмжээнд хамгийн ихээр санаа зовоож буй 4 чухал асуудлын нэг гэж үзсэн бөгөөд ингэж хариулсан залуучуудын 35.8% нь уг асуудлыг дэлхий дахинд хамгийн ихээр тулгамдаж буй асуудал хэмээн үзсэн бол 44.7% нь МУ-д хамгийн ихээр тулгамдаж байгаа асуудал хэмээн тодорхойлж байна. Харин нийт судалгаанд оролцогчдын 45.2% нь “Улс төрийн оролцоо ба ардчилсан зарчим”-ийг МУ-д ч мөн дэлхий дахинд ч санаа зовох асуудал гэж хараагүй байна. Судалгааны үр дүнгээс харахад уг асуудлыг МУ-д тулгамдаж буй бэрхшээл гэж харж буй залуучуудын хувь дэлхийн дахинд тохиож буй асуудал гэж үзэж буй залуучуудаас 8.9%-иар илүү байна.

Улс төрийн оролцоо, ардчилсан зарчим нь энх тайван нийгмийг бүтээж, нийгэм, эдийн засаг, соёлын тогтвортой хөгжлийг хангах чухал суурийг бүрдүүлдэг. Эдгээр зарчим хэрэгжихгүй байгаа тохиолдолд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүлээн зөвшөөрөгдөх, хуулийн өмнө эрх тэгш байх зэрэг хүний үндсэн эрхэнд шууд заналхийл учруулж болно.<sup>12</sup>

МУ 1990 онд нэг намын тогтолцооноос, олон намын тогтолцоо бүхий ардчилсан улс төрийн тогтолцоонд харьцангуй тайван замаар шилжсэн билээ. Хэдийгээр МУ ардчиллыг амжилттай бэхжүүлж буй боловч, улс төрийн тогтворгүй байдал, хангалттай төгөлдөржөөгүй эрх мэдлийн харилцан хяналт-тэнцлийн механизм, авлиа, хээл хахууль, орлогын тэгш бус байдал, баян ядуугийн хэт зөрүү, улс төрчдийн эрх мэдлээ урвуулан ашиглах явдал, иргэд ардчилалд итгэл алдрах зэрэг олон сорилт тулгараад байна.<sup>13</sup>


Цаашлаад “Улс төрийн оролцоо ба ардчилсан

зарчим”-ыг асуудал гэж харж буй залуучуудыг орон нутгийн байршлаар нь харьцуулж үзэхэд сөрөг хамаарал гарсан ( $r = -.099$ ,  $p = .015$ ) бөгөөд тодруулбал Улаанбаатар хотод амьдарч буй залуус улс төрийн оролцоо, ардчиллын зарчмыг хөдөө, орон нутаг дахь залуучуудаас илүү түлхүү анхаарч байна. Энэ нь Улаанбаатар хотод амьдарч буй хүүхэд, залуус улс төрийн талаар илүү их мэдээлэлтэй, улс төрийн системтэй ойрхон амьдарч, үүнийхээ хүрээнд жагсаал цуглаанд оролцох гэх зэрэг улс төрийн оролцоо өндөр байдагтай холбоотой байж болох юм. “Улс төрийн оролцоо ба ардчилсан зарчим”-ыг асуудал гэж сонгосон залуучуудыг насаар нь харьцуулж үзэхэд 18-21 насны иргэд хамгийн ихээр санаа зовж байна. Энэ нь 18 наснаас эхлэн залуучууд нийгмийн харилцаанд илүү бие даасан байдлаар хандаж, оролцож эхэлдэг ба тэр утгаараа өөрсдийн улс төрийн үүргээ ухамсарлаж, улс төрийн оролцоо нь нэмэгдэж байдагтай холбоотой юм

<sup>12</sup> The World in 2030: Public Survey Report. (2021). UNESCO Publishing.


<sup>13</sup> Ж. Төртөгтох, П.Амаржаргал, & С. Ганзаяа. (2020). Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа. Конрад-Аденауэр-Сан.

## ДЭЛХИЙД



Улс төрийн оролцоо ба ардчилсан зарчмыг сонгосон оролцогчдын хүйс, нас, байршлаар харьцуулсан %

## МОНГОЛД



Улс төрийн оролцоо ба ардчилсан зарчмыг сонгосон оролцогчдын хүйс, нас, байршлаар харьцуулсан %


# 2.4

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН АЛДАГДАЛ

/Нийт оролцогчдын 50.2% нь сонгосон/



Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдлыг сонгосон оролцогчдын хэв маяг, % (n=600)




Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудлын нэг болоод байна. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цаг агаар эрс дулаарч, мөнх цас, мөсөн голууд хайлж, далай тэнгисийн усны түвшин нэмэгдэн, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэх болсон.<sup>14</sup> Уур амьсгалын өөрчлөлт сүүлийн хэдэн арван жилийн турш хөгжлийг сааруулж, эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болоод байгаа билээ. Дэлхийн улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар үндэсний төлөвлөгөөгөө гаргаж, таван жил тутам сайжруулж байх үүрэг хүлээсэн Парисын хэлэлцээрийг амьдралд хэрэгжүүлэх үйл ажиллагааны тогтолцоотой. Хэрвээ энэ чиглэлд дорвитой арга хэмжээ авахгүй бол эх дэлхийг сүйрүүлэх аюул ойрхон байна.<sup>15</sup>


Нийт судалгаанд оролцогчдын 50.2% нь “Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал”-ыг дэлхийд аль эсвэл МУ-ын хэмжээнд хамгийн ихээр санаа зовоож буй 4 гол асуудлын нэг гэж үзсэн бөгөөд ингэж үзэж буй залуучуудын 44.5% нь уг асуудлыг дэлхийн дахинд хамгийн ихээр тулгамдаж буй асуудлын нэг гэж хариулсан бол 23.3% нь МУ-д хамгийн ихээр тулгамдаж байгаа асуудлын нэг гэж хариулжээ. Харин нийт судалгаанд оролцогчдын 49.8% нь “Уур амьсгалын өөрчлөлт”-ийг МУ-д ч мөн дэлхий дахинд ч санаа зовох асуудал гэж хараагүй байна. Судалгааны үр дүнгээс харахад уг асуудлыг дэлхийн дахинд тохиож буй бэрхшээл гэж харж буй залуучуудын хувь зөвхөн МУ-д тулгамдаж буй асуудал гэж үзэж буй залуучуудаас 18.2%-иар илүү байна. Эндээс залуучууд уг асуудлыг дэлхий нийтэд тулгарч буй бэрхшээл гэж үзэж буй боловч уур амьсгалын өөрчлөлтийг МУ-ын хувьд төдийлөн чухал асуудал гэж үзэхгүй байгааг харж болно.

Харин уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдлыг ойрын 10 жилд дэлхий дахинд тулгараад байгаа гол асуудлын нэг гэж сонгосон залуучууд болон тэдний орон нутгийн байршлын хооронд сөрөг хамаарал байна. Энэ нь **Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан залуучууд хөдөө, орон нутгийн залуучуудаас илүүтэй уур амьсгалын өөрчлөлтийг санаа зовниж байна.** Үүнийг Улаанбаатар хотод амьдарч буй залуучуудын мэдээллийн хүртээмж, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх сурталчилгаа, ухуулга Улаанбаатар хотод харьцангуй их явагдаж буйтай холбоотой байна. Уур амьсгалын өөрчлөлтийг сонгосон залуучуудыг насаар нь ангилж үзэхэд 18-аас доош насныхны 34.9% нь, 18-21 насныхны 51.9% нь, 21-ээс дээш насныхны 57.1% тус тус уг асуудлыг сонгосон байна. Эндээс 21-24 насны залуучууд уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал гэсэн асуудал хамгийн ихээр зовниж байна.

### ДЭЛХИЙД



### МОНГОЛД



<sup>14</sup> Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх асуудлаарх хамтын ажиллагааны уриалга гаргалаа - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар. (2022, 3-р сарын 29). Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар.

<sup>15</sup> Хүн ба Эх дэлхийн төлөө уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дорвитой арга хэмжээ авах цаг нь яг одоо. (2021, 04 22). UNICEF.


# 2.5

## ЗОХИСТОЙ АЖЛЫН БАЙР БОЛОН БОЛОМЖ

/Нийт оролцогчдын 40.3% нь сонгосон/



Зохистой ажлын байр болон боломжийг сонгосон оролцогчдын хэв маяг, % (n=600)



Судалгаанд оролцсон залуучуудын 40.3% нь “Зохистой ажлын байр болон боломж” гэсэн асуудал ойрын 10 жилдээ МУ-д сайн сайхан нийгмийг цогцлооход хамгийн ихээр санаа зовоож буй 4 асуудлын нэгээр сонгожээ. Зохистой ажлын байрны асуудлыг МУ-д тулгамдаж буй асуудлаар нэрлэж буй залуучуудыг боловсролын түвшнээр нь ангилж үзэхэд судалгаанд хамрагдсан нийт их дээд сургуульд суралцаж буй оюутан залуусын 31.4% нь, их сургууль төгссөн залуучуудын 45.5% нь уг асуудлыг сонгосон байна.

Энэхүү асуудлын онцлог нь ирэх 10 жилд дэлхий дахинд тулгамдаж болзошгүй асуудлаар “Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал”-ыг нэрлэсэн уг асуудал нь МУ-д тулгамдаж буй асуудлаар нэрлэгдээгүй бөгөөд үүний оронд “Зохистой ажлын байр болон боломж” гэсэн асуудлыг залуучууд МУ-ын хэмжээнд илүү санаа зовоож буй асуудал хэмээн үзжээ.

Хүмүүс илүү олноороо зохистой хөдөлмөр эрхэлнэ гэдэг нь эдийн засаг илүү хурдацтай, хүртээмжтэй өснө гэсэн үг. Ажлын байр бий болгох асуудлыг эдийн засгийн бодлого, хөгжлийн төлөвлөлтийн цөм болгосноор зөвхөн зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлээд зогсохгүй, илүү тууштай, хүртээмжтэй, ядуурлыг бууруулсан өсөлтийг бий болгоно.<sup>16</sup> Ийм ч учраас бүх нийтийн зохистой хөдөлмөр эрхлэлт нь “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр” болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын эрхэм зорилго болж тусгагдсан юм.

МУ-ын хувьд залуучуудын дунд ажилгүйдлийн түвшин өндөр байгаа бөгөөд 2018 оны статистик мэдээгээс харахад ихэвчлэн залуу хүмүүс, ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орогчид ажилгүйдэлд илүү өртөж байна. Бүр тодруулбал, нийт ажил эрхлээгүй хүн

амын 56.1% нь 15-34 насныхан, 19.5% нь ажиллах хүчинд шинээр элсэн орсон 20-24 насныхан байна. Нийт ажилгүй иргэдийн 25.3%-ийг 15-24 насны залуучууд эзэлж байна.<sup>17</sup>



Эндээс харахад их сургуулиа дөнгөж төгсөөд буй 21-24 насны ажлын туршлага хуримтлуулж амжаагүй байгаа залуучууд энэ асуудлыг сонгох тохиолдол бага зэрэг өндөр байна. Энэ нь ажлын байр олгогчид шинэ төгсөгчдөөс ажлын туршлага шаарддаг мөн ажлын туршлагагүй хүнд олгох цалингийн хэмжээ доогуур байдаг зэргээс үүдэн уг асуудалд 21-24 насны залуус арай илүү санаа зовниж байх магадлалтай. Иймээс залуучуудыг оюутан байх хугацаанд нь ажлын туршлага хуримтлуулах боломж бололцоог бий болгох, ажлын туршлагагүй ч гэсэн мэргэжлээрээ зохистой цалинтай ажилд орох боломжийг сайжруулах хэрэгтэй байна. Мөн түүнчлэн хөдөө орон нутгаас судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын 32,1% нь, Улаанбаатар хотоос хамрагдсан оролцогчдын 24,3% нь уг асуудлыг нэрлэсэн бөгөөд эндээс хөдөө орон нутгуудад зохистой ажлын байрны асуудал илүү тулгамдаад байна. Эндээс хөдөө орон нутагт залууст зориулсан ажлын байрыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг харж болно.

<sup>16</sup>Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. (2017). Зохистой хөдөлмөр ба 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр.

<sup>17</sup>Залуусын хөдөлмөр эрхлэлт. (2020, 09 16). Youth of Mongolia.





## ДЭЛХИЙД



Зохистой ажлын байр болон боломжийг сонгосон оролцогчдын хүйс, нас, байршлаар харьцуулсан %



## МОНГОЛД



Зохистой ажлын байр болон боломжийг сонгосон оролцогчдын хүйс, нас, байршлаар харьцуулсан %

## БҮЛЭГ 3: ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-2030 БА ЗАЛУУЧУУД





“Тогтвортой хөгжлийн зорилго-2030” нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм. Уг хөтөлбөрийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болсон “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл билээ. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1-р сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн. ТХЗ-ыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан МУ хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор МУ-ын хөгжлийн бодлого,

төлөвлөлтийн тухай хуулийг 2015 оны 11-р сард баталсан. МУ “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийг дэлхийн ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилттой уялдуулан 4 бүлэг, 44 зорилттойгоор 2016 оны 2-р сард УИХ-ын тогтоолоор баталсан.<sup>18</sup>

Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт, үйл ажиллагаа нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийн хүчин чармайлтын хүрээнд залуучуудын хөгжих боломжийг нэмэгдүүлж байгааг Дэлхийн залуучуудын тайланд онцолсон байна. Мөн уг тайланд ТХЗ-2030 хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой алхмуудын нэгээр олон талт, тэгш хүртээмжтэй бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлж, хяналт тавихад оролцох залуучуудын оролцоо хэмээн дурджээ.<sup>19</sup>

Энэ бүлэгт тогтвортой хөгжлийн зорилгын талаарх залуучуудын мэдлэг, мөн тогтвортой хөгжлийн зорилгуудаас залуучуудын хувьд хамгийн чухал зорилгуудыг авч үзнэ.



<sup>18</sup> Mongolian SDG dashboard. (2022). sdg.gov.mn.



<sup>19</sup> WORLD YOUTH REPORT. (2018, December 30). the United Nations.

# 3.1




## ТХЗ-2030 ТАЛААРХ ЗАЛУУЧУУДЫН МЭДЛЭГ,

“Залуучуудын дуу хоолой” судалгааны үр дүнгээс харахад МУ-ын залуучуудын ТХЗ-2030 талаарх мэдлэг ойлголт хангалтгүй түвшинд байгааг харж болно. Судалгаанд оролцогчдын ердөө 3.2% нь ТХЗ-ын талаар маш сайн мэддэг гэж хариулсан бол 18.7% нь сайн мэддэг гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 51.9% нь ТХЗ-2030-ын талаарх мэдлэгээ дунд түвшинтэй хэмээн хариулсан бол 18% нь ТХЗ талаар муу болон маш муу мэддэг гэж хариулжээ. Харин 8.2% нь ТХЗ-ын талаар огт мэдэхгүй байна. ТХЗ 2030-ын талаарх мэдлэгийн түвшинг судалгаанд оролцогчдын боловсролын түвшинтэй харьцуулж үзэхэд залуучуудын боловсролын түвшин нэмэгдэх тусам ТХЗ-2030 талаарх мэдлэг, ойлголтын хувь нэмэгдэж байна. Тухайлбал судалгаанд оролцсон ЕБС-ийн сурагчдын 10.9% нь ТХЗ-ын талаар огт мэдэхгүй гэж хариулсан бол их, дээд сургууль төгссөн 24 хүртэлх насны залуучуудын 4.1% нь ТХЗ-ын талаар огт мэдэхгүй гэж хариулсан. Мөн ТХЗ-ын талаар сайн мэднэ гэж хариулсан залуучуудын хувь боловсролын түвшин дээшлэх бүрд нэмэгдэж байна. Тодруулбал ЕБС-ийн сурагчдын 15.2% нь ТХЗ-2030 талаар сайн мэднэ гэж хариулсан бол их, дээд сургуулийн оюутнуудын 19.8%


нь, их сургууль төгссөн залуучуудын 28.8% нь уг зорилгуудын талаар сайн мэднэ гэж хариулсан. Өөрөөр хэлбэл боловсролын **түвшин өндөр болох тусам тогтвортой хөгжлийн зорилгуудын талаарх мэдлэг, ойлголт нэмэгдэж байна.**



ТХЗ-ын талаар залуучуудын мэдлэг, ойлголт, % (n=600)




Хөдөө, орон нутагт амьдарч буй залуучуудын хувьд “Хүчирхийлэл, зөрчил мөргөлдөөн” илүү сэтгэл зовоосон асуудал байна.



Харин судалгаанд оролцогчдын 9.8% нь ажлын байрны хомсдол, ажилгүйдэл, 9% нь боловсролын салбар, 8.4% нь эдийн засгийн асуудлыг тусгаагүй хэмээн үзэж байна. Гэтэл “эдийн засаг” болон “ажлын байр”-тай холбоотой асуудлыг Тогтвортой хөгжлийн 8-р зорилго буюу Эдийн засгийн өсөлт баталгаат ажлын байрыг бий болгох хэсэгт 12 зорилт 17 үзүүлэлттэйгээр оруулсан байдаг. Мөн боловсролын салбарын асуудлыг Тогтвортой хөгжлийн 4-р зорилго буюу Чанартай боловсролыг дэмжих хэсэгт 10 зорилго, 11 үзүүлэлттэйгээр баталж, үүний хэрэгжилтийг хангахаар НҮБ-ын гишүүн орнууд бодлого, чиглэл боловсруулан ажиллаж байна. Аль хэдийн **ТХЗ-уудад тусгагдсан асуудлыг орхигдсон асуудал хэмээн нэрлэж байгаа нь залуучууд ТХЗ-ын талаар зохих түвшний мэдлэггүй байгааг харуулж байна. Залуучуудын 82% нь ТХЗ-ын талаар дунд болон түүнээс доош түвшинд л мэднэ гэж хариулсантай харьцуулан харвал 16-24 насны залуучуудын ТХЗ-ын талаар хангалттай мэдлэггүй байна.** Тиймээс залуучуудад Тогтвортой хөгжлийн зорилгын талаар таниулан сурталчлах, хэрэгжилтэд оролцох боломжийг нэмэгдүүлэх хэрэгцээ байна. Залуучуудын ТХЗ-ын талаар ойлголтыг сайжруулж байж хэрэгжилтэд залуучуудыг татан оролцуулах боломж нэмэгдэх юм. Дараагийн бүлэгт ТХЗ-ын талаарх Монголын залуучуудын үзэл бодлыг танилцуулах бөгөөд ингэхдээ тогтвортой хөгжлийн зорилгуудын ач холбогдлыг эрэмбэлэн, судалгаанд оролцогчдын хариултыг хүн ам зүйн үндэслэлээр харьцуулсан болно.

Залуучуудын бодлоор ТХЗ-д тусгагдаагүй асуудлууд, %



# 3.2

## МОНГОЛ ЗАЛУУЧУУДЫН БОДЛООР ХАМГИЙН ЧУХАЛ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД

Тогтвортой хөгжлийн зорилгуудаас залуучуудын хамгийн чухалчилж буй зорилгууд:

- ТХЗ-4: Чанартай боловсролыг дэмжих (67.5%)
- ТХЗ-3: Эрүүл мэндийг дэмжих (60.5%)
- ТХЗ-1: Ядуурлыг устгах (41.8%) гэсэн зорилгуудыг нэрлэжээ.


Харин эдгээр зорилгуудыг хамгийн бага хувьтай сонгожээ.

- ТХЗ-12:Хариуцлагатай хэрэглээг дэмжих (1.5%),
- ТХЗ-14: Далай тэнгисийн нөөцийг хамгаалах (2%),
- ТХЗ-11: Ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих (3.3%)

Эндээс харахад Монгол залуучуудын боловсрол, эрүүл мэнд, эдийн засгийн салбарт хамгийн өндөр ач холбогдол өгч байна. Харин нөгөө талаас МУ далайд гарцгүй улс учраас далай тэнгисийг хамгаалах тухай зорилгод ач холбогдол бага өгч байна.

Судалгаанд хамрагдсан нийт ЕБС-ийн сурагчдын 62.7%, их дээд сургуулийн оюутнуудын 71.7%, их дээд сургууль төгсөгчдийн 76.3% нь ТХЗ-4: Чанартай боловсрол зорилгыг залуучуудад хамгийн чухал 3 зорилгын нэгээр сонгожээ. Эндээс харвал боловсролын түвшнээс үл хамааран залуучуудын дийлэнх нь чанартай боловсролын асуудлыг чухалд тооцож байгаа төдийгүй боловсролын түвшин нэмэгдэх тусам уг асуудалд ач холбогдол өгөх хувь нь нэмэгдэж байна.

Залуучуудын бодлоор тогтвортой хөгжлийн хамгийн чухал зорилгууд, %




Түүнчлэн монголчуудад тулгарч буй сорилт бэрхшээлүүдийг шийдвэрлэх талаар залуучуудын саналыг сонсоход УИХ-ын үйл ажиллагааг сайжруулах, хяналт тавих гэсэн шийдлийг хамгийн ихээр дэвшүүлсэн байна.



Чанартай боловсролыг дэмжих зорилгыг сонгосон оролцогчдын боловсролын түвшний харьцаа, %

Эрүүл мэндийг дэмжих зорилгыг судалгаанд оролцогчдын 60.5% нь залуучуудын хувьд хамгийн чухал зорилгын нэгээр сонгосон. Уг зорилгыг хүйсээр нь ангилж үзвэл нийт судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 63% нь, эмэгтэйчүүдийн 59% байна.



Эрүүл мэндийг дэмжих зорилгыг сонгосон оролцогчдын хүйсийн харьцаа, %

Судалгаанд оролцогчдын 94.2% нь ТХЗ-аар дамжуулан залуучуудад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжтой хэмээн үзэж байна. Судалгаанд оролцсон ЕБС-ийн сурагчдын 52.2%, оюутнуудын 36.1% нь, төгсөгчдийн 20.8% нь ТХЗ-1 буюу ядуурлыг устгах зорилгыг хамгийн чухал 3 зорилгын нэгээр нэрлэсэн байна.

ТХЗ-аар дамжуулан залуучуудад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжтой эсэх, %

Эрүүл мэндийг дэмжих зорилгыг сонгосон залуучуудыг боловсролын түвшнээр нь ангилж үзэхэд судалгаанд хамрагдсан нийт ЕБС-ийн сурагчдын 57.8% нь, оюутнуудын 69.4% нь, их дээд сургууль төгсөгчдийн 45.8% нь уг зорилгыг сонгосон. Их, дээд сургуулийн оюутнуудыг хувьд ТХЗ-3: Эрүүл мэндийг дэмжих зорилго хамгийн чухалд тооцогдож байгааг эндээс харж болно.




## БҮЛЭГ 4: ЗАЛУУЧУУДАД ТУЛГАМДАЖ БҮЙ СОРИЛТ БЭРХШЭЭЛ

---



Судалгаанд оролцогчдын ирээдүйн талаарх төсөөлөл, %




51.8% нь 2030 он гэхэд Монголын залуучуудын нөхцөл байдал одоогийнхтой харьцуулбал сайжирна гэж үзсэн.

Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан залуучууд өөрсдийгөө хэрхэн тодорхойлж байгаа болон тэдэнд ямар асуудал, бэрхшээл тулгарч байгаа болон тухайн асуудлыг шийдвэрлэхэд залуучуудын гаргаж буй санал шийдлүүдийг танилцуулна. Судалгаанд оролцогчдын 43.6% нь залуу хүн гэдгийг эрч хүчтэй, хүсэл тэмүүлэлтэй хүн, 25% нь ажиллаж хөдөлмөрлөх насныхан, 20.5% нь улс орны ирээдүй, 15.5% нь шинийг эрэлхийлэгч гэсэн ухагдахуунаар тодорхойлж байна.


Тодруулбал 45.7% нь 10 жилийн дараах ирээдүйгээ сайхан, амжилттай байна гэж харж байгаа бол 18% нь мөн адил эергээр буюу тогтвортой ажилтай, гэр бүлтэй байгаагаар төсөөлж байна. Харин судалгаанд оролцогчдын 12.7% нь өөрсдийн ирээдүйгээ гадаадад ажиллаж амьдарч эсвэл суралцаж байгаагаар төсөөлж байна гэж хариулсан байна. Ингэхдээ гадаадад амьдарна гэж хариулсан залуучуудын 71% нь эргээд эх орондоо ирнэ гэж хариулсан бол үлдсэн хувь нь эргэж ирэхгүй байхыг хүсэж байна гэж хариулсан. Эндээс ажиллаж, хөдөлмөрлөх насны залуучууд эх орноосоо холдож гарах хүсэл эрмэлзэл ихтэй байгааг харж болно.

Залуучуудын ирээдүйн талаарх төсөөлөл эерэг байгаагаар адилаар залуучууд өөрсдийнхөө нийгэмд оруулах үүргийг өндрөөр үнэлж буй эерэг дүр зураг харагдаж байна. Тухайлбал 63.5% нь нийгэмд оруулах хувь нэмрээ их болон маш их гэж тодорхойлсон бол 8% нь бага, маш бага гэж үзэж байна.

Судалгаанд оролцогчдын 51.8% нь 2030 он гэхэд Монголын залуучуудын нөхцөл байдал одоогийнхтой харьцуулбал сайжирна гэсэн бол, 10.5% нь муудна хэмээн үзэж байна.



Залуучуудын нийгэмд гүйцэтгэх үүргийн хэмжээ, %



Монголын залуучуудын 10 жилийн дараах нөхцөл байдал, %

# 4.1 АЖЛЫН БАЙРНЫ ХОМСДОЛ БА ЦАЛИНГИЙН

Судалгаанд оролцогчдын 31% нь ажилгүйдлийг Монголын залуучуудад хамгийн ихээр тулгамдаж буй асуудал хэмээн үзэж байна. 2-р бүлэгт дурдсанчлан МУ-ын хэмжээнд залуучуудын дунд ялангуяа 24 хүртэлх насныхны дунд ажилгүйдлийн түвшин өндөр байна. Залуучууд уг асуудлыг сонгохдоо ажлын туршлага байхгүй учир

ажлын байр олдоггүй, эсвэл шинэ төгсөгч учир цалин бага, ажлын байр олдсон ч хэт олон цагаар ажиллуулдаг, ажлын байрны аюулгүй орчин хангалттай биш байдаг гэх зэрэг асуудлуудыг нэрлэсэн байна.

## Шийдлүүд:



Ажлын байрны хомсдол ба цалингийн хүртээмжийг асуудал гэж сонгосон оролцогчдыг, ажил эрхлэлтийн түвшинтэй харьцуулж үзэхэд судалгаанд оролцсон ажил эрхэлдэг залуучуудын 36.6% нь цалингийн хүртээмжийг нэмэгдүүлэх эсвэл ажиллах орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай гэж хариулсан байна. Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын 28.3% нь ажилгүйдэл ба цалингийн хүртээмжийн асуудлыг сонгосон бол орон нутгаас оролцсон залуучуудын 33.3% нь уг асуудал хэмээн харж байна. Эндээс харахад ажлын байрны асуудал нь хөдөө орон нутагт Улаанбаатар хотоос 5%-иар илүү их тулгамдаад байгаа асуудал ажээ. Иймээс хөдөө орон нутагт шинээр ажлын байрыг бий болгож, ажиллах

орчныг сайжруулах хэрэгтэй байна.

Мөн судалгаанд оролцсон залуучуудын 14.2% нь боловсролын чанарыг сайжруулах нь уг асуудлыг шийдвэрлэх арга юм гэж үзжээ. Учир нь хот хөдөө, баян ядуу, эрэгтэй эмэгтэй гэж хэнийг ч ялгахгүй адил тэгш чанартай боловсрол эзэмшиж чадвал ирээдүйд түүгээрээ дамжуулан өөрт тохирсон ажлын байранд хүрэх боломжтой юм. Уг хариулт нь 2020 онд ЮНЕСКО-оос гаргасан “World in 2030” судалгааны дүнд мөн дурдагдсан бөгөөд уг судалгааны тайланд зохистой ажлын байрны асуудлыг шийдвэрлэхийн тулд бүх нийтэд чанартай боловсрол олгох нь хамгийн оновчтой шийдэл гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь хариулсан байна.<sup>20</sup>

<sup>20</sup> The World in 2030: Public Survey Report. (2021). UNESCO Publishing.



## 4.2 БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

Өмнөх дэд бүлэгт ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэх хамгийн чухал шийдэл мөн хэмээн сонгогдож байсан “Боловсролын чанар”-ын асуудал энэ бүлэгт хүүхэд, залуучуудын хувьд тулгамдаж буй асуудлын нэг хэмээн сонгогджээ. МУ-ын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогод “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүнийг төлөвшүүлэх” алсын харааг боловсрол, сургалтын таван зорилтоор тодорхойлсон байдаг.

Тодруулбал, хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах, Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулах гэх мэт зорилтуудыг тусгасан.<sup>21</sup>

2019 онд ЮНЕСКО-оос гаргасан МУ-ын боловсролын бодлогын тойм шинжилгээний тайлангаас харахад МУ-ын ЕБС-ийн сургалтын түвшний болон хүйсийн ялгаатай байдал өндөр

байгаа учир чанар, тэгш боломжийн асуудалд анхаарал хандуулах хэрэгцээ байна гэсэн дүгнэлт гарчээ.<sup>22</sup>

Судалгаанд хамрагдсан 16-24 насны залуучуудын 11.8% нь боловсролын чанар, хүртээмжийн асуудлыг МУ-ын залуучуудад хамгийн ихээр тулгамдаж байгаа асуудал хэмээн тодорхойлж байна. Судалгаанд оролцогчдыг боловсролын түвшинтэй нь харьцуулж үзэхэд судалгаанд оролцсон нийт оюутнуудын 16.1% нь, ЕБС-ийн сурагчдын болон их, дээд сургууль төгсөгчдийн 9.6% нь тус бүр боловсролын чанарын асуудлыг залуучуудад тулгамдаж буй асуудлын нэг гэж нэрлэсэн байна. Судалгаанд оролцогчдын зүгээс уг асуудлыг шийдвэрлэхийн тулд:

### Шийдлүүд:

- Боловсролын системийг шинэчлэх
- Боловсролыг хүн бүрд хүртээмжтэй болгох
- Боловсролын салбарын ажилтнуудад анхаарах (цалингийн хэмжээг нэмэгдүүлж, ажиллах таатай орчныг бүрдүүлэх, багш нарын чанар)
- Хөдөө орон нутаг дахь боловсролын чанарыг сайжруулах
- Гэр бүл төлөвлөлт, ёс зүй зэрэг ур чадварыг боловсролын системд шингээх
- Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- ЕБС болон их дээд сургуулиудыг сэтгэл зүйчээр хангах
- Их сургуулиудын төлбөрийг бууруулах



<sup>21</sup> “АЛСЫН ХАРАА-2050.” Legalinfo.mn, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=211057&showType=1>.

<sup>22</sup> ЮНЕСКО. Монгол улсын боловсролын салбарын тойм шинжилгээ. Улаанбаатар, 2019.

## 4.3 ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДАЛ

МУ-ын ДНБ нь ердөө 13 тэрбум ам.доллар байна. Тиймээс эдийн засгийн хувьд Номхон далайн болон Карибын тэнгисийн жижиг улсуудыг эс тооцвол дэлхийн жижиг эдийн засагтай орнуудын нэг юм.<sup>23</sup>

Улаанбаатар хотоос нийт судалгаанд оролцсон залуучуудын 8.7% нь, орон нутгаас судалгаанд хамрагдсан оролцогчдын 11.1% нь эдийн засгийн тулгамдсан асуудлыг чухал гэж нэрлэсэн байна. Эндээс эдийн засгийн асуудал нь хөдөө орон нутагт 2.4%-иар илүү тулгамдаад буй асуудал болохыг харж болно. Судалгаанд хамрагдсан залуучууд:

- Үнийн өсөлт
- Хэт өндөр татвар
- Цалин хүрэлцдэггүй гэсэн 3 үндсэн хүчин зүйлийг хамгийн ихээр нэрлэсэн бөгөөд үүний шийдлийг мөн үүнтэй адилаар үнийн өсөлтийг зогсоож, татварыг бууруулах, дундаж цалинг нэмэх гэсэн 3 саналын хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж хариулсан байна.

2022 оны 8-р сарын байдлаар МУ-ын инфляцын түвшин 14.4%<sup>24</sup> болоод байгаа нь ард иргэдийн амьдралыг доройтуулж, залуучуудад хамгийн ихээр тулгамдаж буй асуудлын нэг болоод байна.



<sup>23</sup> Монгол Улсын Эдийн Засгийн хэтийн төлөв: Хоёр том гүрний дунд орших . Азийн хөгжлийн банк.

<sup>24</sup> Монгол Улсын Төв Банк. (2022).

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

**Залуучуудын хувьд дэлхий дахинд болон МУ-ын хэмжээнд санаа зовж буй асуудлууд нь ижил байна.** Залуучуудын хувьд санаа зовниж буй тэргүүлэх 5 асуудлаас дэлхийн болон Монголын түвшинд зөрүүтэй байгаа нь **дэлхийд “Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал”** байгаа бол, Монголд **“Зохистой ажлын байр болон боломж”**-ийг чухалчилж байна.

Хүчирхийлэл, зөрчилдөөн нь дэлхийд мөн МУ-д ч хамгийн ихээр тулгамдаад буй асуудал байгаа бөгөөд хүчирхийлэл, зөрчилдөөн эмэгтэйчүүдийн хамгийн эмзэг тулгамдсан асуудал байна.

Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдлыг ойрын 10 жилд дэлхий дахинд тулгараад байгаа асуудал хэмээн үзэж байна. Улаанбаатар хотоос оролцогчид, орон нутгийн залуучуудаас илүүтэй уур амьсгалын өөрчлөлтөд санаа зовниж байна.

**Залуучуудын ТХЗ-уудын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх хэрэгцээ байна.** ТХЗ-уудын талаар судалгаанд оролцогчдын 51.9% нь дунд бол, 26.2% нь муу болон маш муу мэдлэгтэй байна. Мөн ТХЗ-ууд залуучуудад чиглэсэн асуудлыг хэрхэн тусгаж өгсөн талаар мэдлэг сул байна. Гэсэн хэдий залуучуудын 94.2% нь ТХЗ-аар дамжуулан залуучуудад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжтой хэмээн үзэж байгаа нь ТХЗ-д итгэх итгэл өндөр байгааг харуулж байна. Залуучуудын ТХЗ-уудын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлснээр ТХЗ-ын хэрэгжилтэд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Залуучууд ТХЗ-аас хамгийн ихээр **эдийн засаг буюу ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, боловсрол, эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах** зорилгуудад хамгийн их ач холбогдол өгч, хамгийн чухлаар нэрлэж байна. Өөрөөр хэлбэл залуучуудын хувьд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ чанар, хүртээмжийг сайжруулах асуудал хамгийн чухал байна.

**а) Залуучуудын хувьд тэргүүлэх тулгамдсан асуудал бол ажилгүйдэл байна.** Ажилгүйдлийг бууруулах арга замыг залуучууд ажлын байрыг нэмэгдүүлэх, ажлын байрны ёс зүйг сайжруулах, ажиллахад таатай эрүүл аюулгүй орчинг бий болгох, татварын дарамтыг бууруулах, цалин хангамжийн хэмжээг нэмэгдүүлэх, ажиллах хүчний өрсөлдөх чадвар, оролцооны түвшинг нэмэгдүүлэх хэмээн үзэж байна. Ажил эрхэлдэг залуучуудын хувьд ажлын байрны орчин нөхцөл, эрүүл таатай орчин бий болгох шаардлагатай гэдгийг онцолж байна.

**б) Залуучуудын хувьд хоёрдох тулгамдсан асуудал бол боловсрол болон эрүүл мэндийн тогтолцоо чанар, хүртээмжийг сайжруулах асуудал байна.** Боловсрол болон эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах арга замыг залуучууд тогтолцоог шинэчлэх, үйлчилгээг хүртээмжтэй болгох, салбарын ажилтнуудын нийгмийн баталгааг бүрдүүлэх, цалин хангамжийг нэмэгдүүлэх, ажиллах таатай орчин бүрдүүлэх гэсэн бол, орон нутагт үзүүлж буй үйлчилгээний чанарт анхаарал хандуулах, салбар байгууллагуудын тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний төлбөр бууруулах гэсэн шийдлүүдийг санал болгож байна.

**с) Залуучуудын хувьд гуравдах тулгамдсан асуудал бол үнийн өсөлт, татварын дарамт, цалин хангамжийн хүрэлцээ хэмээн тодорхойлж байна.**

**Залуучууд ойрын 10 жилийн ирээдүйгээ эерэг, сайхнаар төсөөлж, төлөвлөж байна.** Тухайлбал залуучууд залуу хүн гэдгийг улс орны ирээдүй, ажиллаж хөдөлмөрлөх нас, эрч хүчтэй, хүсэл тэмүүлэлтэй, шинийг эрэлхийлэгч хүн гэсэн ухагдахуунаар тодорхойлж, судалгаанд оролцогчдын 45.7% нь ирээдүйгээ сайхан, амжилттай байна гэж харж байгаа бол 18% нь мөн адил эергээр буюу тогтвортой ажилтай, гэр бүлтэй байгаагаар төсөөлж байна.

**Залуучуудын хувьд ойрын 10 жилийн хугацаанд гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн их хэвээр байна.** Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон 10 залуу тутмын 1 нь буюу 12.7% нь өөрсдийн ирээдүйгээ гадаадад ажиллаж амьдарч эсвэл суралцаж байгаагаар төсөөлж байна. Ингэхдээ гадаадад амьдарна гэж хариулсан залуучуудын 71% нь эргээд эх орондоо ирнэ гэж хариулсан бол үлдсэн хувь нь эргэж ирэхгүй байхыг хүсэж байна. Залуучуудын гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн их байгаа шалтгаан нь чанартай боловсрол эзэмшихэд чиглэж байна.

**Залуучууд өөрсдийнхөө нийгэмд оруулах хувь нэмэр, хүлээх үүргийг өндрөөр үнэлж, тодорхойлж байна.** Тухайлбал залуучуудын 63.5% нь нийгэмд оруулах хувь нэмрээ их болон маш их гэж тодорхойлохын зэрэгцээ, 51.8% нь 2030 он гэхэд Монголын залуучуудын нөхцөл байдал одоогийнхтой харьцуулбал сайжирна хэмээн төлөвлөж байна.

# АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## Судалгааны тайлан

### Монгол хэлээр:

1. Залуучуудын санал бодлын судалгаа. (2020). Хараат бус судалгааны хүрээлэн.
2. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. (2017). Зохистой хөдөлмөр ба 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр.
3. Төртогтох, Ж., Амаржаргал, П., & Ганзаяа, С. (2020). Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа (1st ed.). Конрад-Аденауэр-Сан.
4. ЮНЕСКО. Монгол улсын боловсролын салбарын тойм шинжилгээ. Улаанбаатар, 2019.
5. Я.Мөнхчимэг. (2020). Ковид-19 цар тахал тодорхой бүлгийн залууст хэрхэн нөлөөлсөн бэ? Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаа II.

### Англи хэлээр:

1. The World in 2030: Public Survey Report. (2021). UNESCO Publishing.
2. WORLD YOUTH REPORT. (2018, December 30). the United Nations. Retrieved September 30, 2022.

## Цахим эх сурвалж

### Монгол хэлээр:

1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль. (18, 05 2017). Legalinfo.mn. Retrieved September 21, 2022, from <https://legalinfo.mn/mn/detail/12658>
2. Залуусын хөдөлмөр эрхлэлт. (2020, 09 16). Youth of Mongolia. Retrieved September 30, 2022, from <https://www.youth.mn/forum/view/5>
3. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх асуудлаарх хамтын ажиллагааны уриалга гаргалаа - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар. (2022, March 29). Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар. Retrieved September 26, 2022, from <https://president.mn/22938/>
4. Монгол улсын хүн амын тоо, нэг нас, хүйс, насны бүлгээр. (n.d.). Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Retrieved September 30, 2022, from [https://www.1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NSO\\_0300\\_071V3](https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_071V3)

5. Монгол улсын сонгуулийн ерөнхий хороо. (2021.). МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО. Retrieved September 30, 2022, from <https://www.gec.gov.mn/blog/3061>
6. Монгол Улсын Эдийн Засгийн хэтийн төлөв: Хоёр том гүрний дунд орших арг. (2020). Asian Development Bank. Retrieved October 14, 2022, from <https://www.adb.org/sites/default/files/publication/611416/mongolia-economic-prospects-chapter1-mn.pdf>
7. Үндэсний статистикийн хороо. (2022). Статистикийн мэдээ.
8. Хүн ба Эх дэлхийн төлөө уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дорвитой арга хэмжээ авах цаг нь яг одоо. (2021, 04 22). UNICEF. Retrieved September 30, 2022, from [https://www.unicef.org/mongolia/mn/press\\_release/climate-action-people-and-planet-time-now](https://www.unicef.org/mongolia/mn/press_release/climate-action-people-and-planet-time-now)
9. Mongolian SDG dashboard. (2022). sdg.gov.mn. Retrieved September 30, 2022, from <http://sdg.gov.mn/Home/About>

### Англи хэлээр:

1. COVID Live - Coronavirus Statistics. (2022). Worldometer. Retrieved September 30, 2022, from <https://www.worldometers.info/coronavirus/>
2. Youth | United Nations. (n.d.). the United Nations. Retrieved September 20, 2022, from <https://www.un.org/en/global-issues/youth>

## PHOTO CREDIT:

- Page 7 - © UNESCO  
Page 13 - © UNESCO/B.Tsogtbaatar  
Page 14 /© Marko Djurica / Reuters  
Page 16 / montsame.mn  
Page 18 / montsame.mn  
Page 20 / © UNESCO/Evgeniy Kokukhin  
Page 22 / © UNICEF/Evgeniy Maloletka  
Page 24 / © UNICEF  
Page 26/27 United Nations Youth Advisory Panel in Mongolia  
Page 30 / © UNESCO  
Page 33 / © UNESCO  
Page 34 / United Nations Youth Advisory Panel in Mongolia

# ХАВСРАЛТ

ДЭЛХИЙД ОЙРЫН 10 ЖИЛИЙН ХУГАЦААНД САЙН САЙХАН НИЙГМИЙГ ЦОГЦЛОХОД ДАРААХ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫН АЛЬ НЬ ТАНЫ САНААГ ХАМГИЙН ИХЭЭР ЗОВООЖ БАЙНА ВЭ? (4 ХҮРТЭЛХ ХАРИУЛТ СОНГОНО УУ)

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУДААС (ТХЗ-2030) ЗАЛУУЧУУДЫН ХУВЬД ХАМГИЙН ЧУХАЛ ЗОРИЛГУУД ЮУ ВЭ? (3 ХҮРТЭЛХ ХАРИУЛТ СОНГОНО УУ)

- шилжилт хөдөлгөөн /хот, хөдөө болон өөр улс орон/
- уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал
- худал мэдээлэл ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
- хүчирхийлэл, зөрчилдөөн
- эрүүл мэнд, өвчин шаналал
- улс төрийн оролцоо ба ардчилсан зарчим
- хоол хүнс, ус, амьдрах орон байрны хомсдол
- зохистой ажлын байр болон боломж
- хиймэл оюун ухаан, шинэ технологи
- ялгаварлан гадуурхалт ба тэгш бус байдал
- соёл, уламжлал алдагдах
- боловсролын чанар, хүртээмж
- бусад.....

- ТХЗ-1: ядуурлыг устгах
- ТХЗ-2: өлсгөлөнг зогсоох
- ТХЗ-3: эрүүл мэндийг дэмжих
- ТХЗ-4: чанартай боловсролыг дэмжих
- ТХЗ-5: жендерийн эрх тэгш байдлыг хангах
- ТХЗ-6: баталгаат ундны ус ариун цэврийн байгууламжаар хангах
- ТХЗ-7: сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
- ТХЗ-8: эдийн засгийн өсөлт баталгаат ажлын байрыг бий болгох
- ТХЗ-9: инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх
- ТХЗ-10: тэгш бус байдлыг бууруулах
- ТХЗ-11: ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих
- ТХЗ-12: хариуцлагатай хэрэглээг дэмжих
- ТХЗ-13: уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
- ТХЗ-14: далай тэнгисийн нөөцийг хамгаалах
- ТХЗ-15: хуурай газрын экосистемийг хамгаалах
- ТХЗ-16: энх тайван шударга ёсыг цогцлоох
- ТХЗ-17: хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

ТА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУДЫН ТАЛААР ХЭР САЙН МЭДЭХ ВЭ?

ТХЗ-ЫН ЗОРИЛГУУД ЗАЛУУЧУУДАД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖТОЙ ЮУ?

- маш сайн
- сайн
- дунд
- муу
- маш муу
- мэдэхгүй

1. тийм
2. үгүй

МОНГОЛД ОЙРЫН 10 ЖИЛИЙН ХУГАЦААНД САЙН САЙХАН НИЙГМИЙГ ЦОГЦЛООХОД ДАРААХТУЛГАМДАЖБУЙАСУУДЛУУДЫНАЛЬ НЬ ТАНЫ САНААГ ХАМГИЙН ИХЭЭР ЗОВООЖ БАЙНА ВЭ? (4 ХҮРТЭЛХ ХАРИУЛТ СОНГОНО УУ)

- ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН /ХОТ, ХӨДӨӨ БОЛОН ӨӨР УЛС ОРОН/
- УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН АЛДАГДАЛ
- ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ БА ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ
- ХҮЧИРХИЙЛЭЛ, ЗӨРЧИЛДӨӨН
- ЭРҮҮЛ МЭНД, ӨВЧИН ШАНАЛАЛ
- УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО БА АРДЧИЛСАН ЗАРЧИМ
- ХООЛ ХҮНС, УС, АМЬДРАХ ОРОН БАЙРНЫ ХОМСДОЛ
- ЗОХИСТОЙ АЖЛЫН БАЙР БОЛОН БОЛОМЖ
- ХИЙМЭЛ ОЮУН УХААН, ШИНЭ ТЕХНОЛОГИ
- ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА ТЭГШ БУС БАЙДАЛ
- СОЁЛ, УЛАМЖЛАЛ АЛДАГДАХ
- БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖ
- БУСАД

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУДАД (ТХЗ-2030) ЗАЛУУЧУУДАД ТУЛГАРДАГ ЯМАР ЯМАР АСУУДЛУУД ТУСГАГДААГҮЙ ОРХИГДСОН ВЭ?

1. ....
2. ....
3. ....

МОНГОЛЧУУДАД ТУЛГАРЧ БУЙ ЭДГЭЭР АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХИЙН ТУЛД ТАНД ТОХИРОМЖТОЙ ШИЙДЭЛ ЮУ БАЙНА ВЭ?

1. ....
2. ....
3. ....

МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДАД ХАМГИЙН ИХЭЭР ТУЛГАМДАЖ БУЙ ЯМАР АСУУДАЛ, БЭРХШЭЭЛҮҮД БАЙНА ВЭ?

1. ....
2. ....
3. ....

МОНГОЛЫН НИЙГЭМД ЗАЛУУЧУУДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТА ХЭРХЭН ХАРЖ ТОДОРХОЙЛЖ БАЙНА ВЭ?

- МАШ ИХ
- ИХ
- ДУНД ЗЭРЭГ
- БАГА
- МАШ БАГА
- ХЭЛЖ МЭДЭХГҮЙ

ДЭЭРХ ЗАЛУУЧУУДАД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ, БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХАД ТАНД ЯМАР САНАЛ, САНААЧИЛГА, ШИЙДЭЛ БАЙНА ВЭ?

1. ....
2. ....
3. ....

ДЭЭРХ ЗАЛУУЧУУДАД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ, БЭРХШЭЭЛИЙГ ШИЙДВЭРЛЭХИЙН ТУЛД ТА ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

1. ....
2. ....
3. ....

ТАНЫ БОДЛООР 2030 ОН ГЭХЭД МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ ОДООГИЙНХТОЙ ХАРЬЦУУЛБАЛ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨХВЭ?

- МАШ САЙЖИРНА
- САЙЖИРНА
- ДУНД ЗЭРЭГ
- МУУДНА
- МАШ ИХ МУУДНА
- ХЭЛЖ МЭДЭХГҮЙ

ТАНЫ БОДЛООР ЗАЛУУ ХҮН ГЭДЭГ ОЙЛГОЛТ ЯМАР УТГЫГ ИЛЭРХИЙЛЭХ ВЭ?

1. ....
2. ....
3. ....

ТА 10 ЖИЛИЙН ДАРААХ ИРЭЭДҮЙГЭЭ ХЭРХЭН ТӨСӨӨЛЖ БАЙНА ВЭ?

ХАЯГ:	<input type="checkbox"/> НИЙСЛЭЛ: ..... <input type="checkbox"/> ОРОН НУТАГ: .....
ТАНЫ НАС:	.....
ТАНЫ ХҮЙС	<input type="checkbox"/> ЭРЭГТЭЙ <input type="checkbox"/> ЭМЭГТЭЙ
ТАНЫ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН	<input type="checkbox"/> ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧ <input type="checkbox"/> ОЮУТАН <input type="checkbox"/> ИХ ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГССӨН <input type="checkbox"/> СУРГУУЛЬД СУРАЛЦАХГҮЙ БАЙГАА <input type="checkbox"/> БУСАД /...../
ТАНЫ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ:	<input type="checkbox"/> АЖИЛ ЭРХЭЛДЭГ <input type="checkbox"/> АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ
ТАНД НИЙГМИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОХОД ЯМАР НЭГЭН БЭРХШЭЭЛ ТУЛГАРДАГ УУ?	<ol style="list-style-type: none"> <li>1. ТИЙМ..... /ТОДРУУЛАХ/</li> <li>2. ҮГҮЙ</li> <li>3. ХАРИУЛАХААС ТАТГАЛЗСАН</li> </ol>
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭСЭХ	<input type="checkbox"/> ТИЙМ <input type="checkbox"/> ҮГҮЙ